



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

310 дугаар байр, Лувсанданжанцангийн өргөн чөлөө 3,  
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101, Утас:(976) 70443206,  
Цахим шуудан: munkhsaikhan@bayankhongor.gov.mn  
Цахим хаяг:www. bayankhongor.gov.mn

2024.02.23 № 19/138

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г СУМ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРТ Г

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад зориулан хандив авахтай холбогдсон хориглолт хязгаарлалтыг зөрчихгүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудаатай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624000185

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС

ЗӨВЛӨМЖ

2024 оны 02 дугаар сарын 22

Номгон

Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ  
хандив авахтай холбогдсон хориглолт  
хязгаарлалтыг анхаарч ажиллах тухай

Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, зохион байгуулж оролцох, хүсэхийг хуулиар хориглосон. Хуульд хориглоогүй хэлбэрээр буюу сайн дураар нийтийн албанд үзүүлсэн тусламж, өгсөн хандивыг хүлээн авах, захиран зарцуулахад Нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөн, тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийн тайлан гаргах, төсвөөс санхүүжилтийн зарцуулалтад тавигдах шаардлагыг нэгэн адил баримтлан, хууль тогтоомжийн хүрээнд удирдлагын шийдвэрийг гаргуулах зорилгоор дараах ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж байна.

Зөвлөмж-1

Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийг материаллаг бүрэлдэхүүнтэй байсныг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болгосон. Өөрөөр хэлбэл хандив авахыг хүссэн л бол Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг зөрчсөнд тооцон хуулийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болох тул урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллах;

Зөвлөмж-2

Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т Төрийн байгууллага, албан тушаалтан аливаа төрлийн хандив, санхүүгийн туслалцааг нийтийн албаны хэрэгцээ, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэгт албан үүрэгтэй нь холбоогүй гуравдагч этгээдээс хүлээн авах боломжтой. Мөн Төсвийн тухай хуулиар зөвхөн эх үүсвэр нь дутагдсан эмнэлэг, боловсрол, соёлын үйлчилгээнд болон сургалтын хөтөлбөрт л хандив, санхүүгийн туслалцааг хүлээн

авах боломжтой эдгээрээс бусад тохиолдлыг хуулиар хориглосон тул хэрэгжилтийг ханган ажиллах;

#### Зөвлөмж-3

Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т зааснаар албан тушаалтан хандив санхүүгийн туслалцаа авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна гэсэн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

#### Зөвлөмж-4

Албан тушаалтан өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээд, ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээд, удирдлага, хяналт, захиргааны албанд нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд хандивыг хүсэх, цуглуулахад оролцохгүй байх, биечлэн, зуучлуулах замаар харилцахгүй байхад анхаарч ажиллах;

#### Зөвлөмж-5

Нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөн хуулийн дагуу хандив авсан тохиолдолд орлого, зарцуулалтын талаар байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт энгийн ойлгомжтой байдлаар тухай бүр байршуулан иргэд, олон нийтийг нээлттэй мэдээлэл авах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийн тайланг гаргах, төсвөөс санхүүжилтийн зарцуулалтад тавигдах шаардлагыг нэгэн адил баримтлан хууль тогтоомж зөрчихөөс урьдчилсан сэргийлэхэд анхаарч ажиллах;

#### Зөвлөмж-6

Засгийн газар болон төсвийн байгууллагын Төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн банк дахь дансны удирдлагыг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага, тайлагнахтай холбогдсон харилцааг төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу зохион байгуулах;

#### Зөвлөмж-7

Сум, байгууллага байгуулагдсаны ой, үндэсний баяр наадмыг тэмдэглэхтэй холбоотойгоор олон нийтэд чиглэсэн хандав, тусламж цуглуулах зорилгоор удирдах ажилтны гарын үсэг бүхий албан бичгийг хүргүүлэх, захирамжаар хандив, тусламж цуглуулах ажлыг хариуцан зохион байгуулах комисс томилж ажлын хэсгийг

байгуулах, төрийн албан хаагчдын цалингаас зохион байгуулалттайгаар тэгшитгэсэн байдлаар хандив гэж албан журмаар хураан авах, айл, өрхүүдээс тогтоосон мөнгөн дүнгээр хандив хураан авах, эсвэл мал бусад бараа материалыг татах, төсвийн байгууллагуудын цуглуулсан хандивын дүнг ажлын үзүүлэлт болгон журамлах, үзвэр, үйлчилгээ, концертын тоглолтын билетийг тарааж мөнгийг хураан авах, аж ахуйн нэгжүүдээс эзэмшдэг газрын га тутамд тариф тогтоож хандив авах, ашиглалтын болон хайгуулын лицензтэй аж ахуйн нэгжүүдээс Ашигт малтмалын тухай хуулийг барин байнгын, тогтмол, давтамжтайгаар хандив, тусламж авах зэрэг байдлаар хууль тогтоомжийг зөрчихгүй, сайн дурын үндсэн зарчмыг гажуудуулахгүй байх;

#### Зөвлөмж-8

Төсвийн тухай хуульд заасан хандивлаж байгаа зүйл нь тухайн эх үүсвэр нь дутагдсан арга хэмжээ, үйл ажиллагааны зардлын 50 хувиас хэтэрч болохгүй гэсэн заалтын хэрэгжилтийг ханган ажиллах;

#### Зөвлөмж-9

Нийтийн албан тушаалтан нь албаны бүрэн эрхээ хэрэгжүүлж үнэн зөв шийдвэр гаргахтай холбоотойгоор хөндлөнгийн хууль бус нөлөөнд автахгүй байж төрийн албан хаагч, иргэд, аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагуудад хандивтай холбоотой хуулийн зохицуулалтыг таниулах, хандив шаардах, нэхэх тохиолдолд энэ талаар /Удирдах албан тушаалтан, Авлигатай тэмцэх газрын "110" тусгай дугаарт/ нэн даруй мэдэгдэх;

#### Зөвлөмж-10

Төсвийн тухай хуулиар "хандив хүлээн авсан этгээд тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, эсвэл аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ" гэсэн заалтын хэрэгжилтийг ханган ажиллах;

#### Зөвлөмж-11

Иргэд, олон нийтэд хандивтай холбоотой асуудлаар мэдээлэл өгөх, хуулийн хориглосон байдлыг таниулах, ямар ч тохиолдолд хандив нь сайн дурын байх зарчмыг ойлгуулах чиглэлээр соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажиллах;

#### Зөвлөмж-12

Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнуудад хандивтай холбоотой хуулийн зохицуулалт, дүрэм журам зэргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан биелэлтийг хагас жилээр /6 дугаар сарын 10/ бүтэн жилээр /11 дүгээр сарын 25-ны дотор/ тайлагнан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг зөвлөө.



ХЯНАСАН  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.САРАНГАРАВ

БОЛОВСРУУЛСАН,  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Ж.ЛХАМДУЛАМ